

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2023 ОНЫ 8 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

2023 оны 8 дугаар сарын 14-нд аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллаж, сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, үүрэг даалгавар өгсний дагуу сумын Засаг даргын тамгын газар нь 08 дугаар сарын 15-аас эхлэн сумын Соёлын төвийн байрын 1 давхарт шилжин байршиж, өрөө тасалгааг хуваарилан, байгууллагыг хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг хангалаа.

"Алтан овоо"-ны тэнгэрийг тайх Төрийн их тахилга 110 жилийн ойн баяр наадамд сумын Засаг даргын тамгын газраас 5,5 сая төгрөгийг зарцуулан оролцлоо. Баяр наадмын үеэр наадмын хуушуур, хоол үйлдвэрлэл, худалдаа, хүүхдийн тоглоомын үйлчилгээ эрхлэх хүсэлтэй аж ахуй нэгж, иргэдийн өргөдөл бүрдүүлэх материалыг 2 иргэнээс хүлээн авч, зөвшөөрөл гаргуулсан.

8 дугаар сарын 22-нд Үнэгт багийн, 8 дугаар сарын 23-нд Дэлгэрхаан багийн иргэдийн нийтийн хурал тус тус хуралдлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолын дагуу "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, үзүүлсэн тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж ажилласан ажлын мэдээг 8 дугаар сарын 20-нд аймгийн ГБХЗХГазарт хүргүүлсэн.

"Түвшин манлай хурд" морин спорт уяачдын холбоо байгуулагдсны 11 жилийн ойн баяр наадам 08 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдаж 5 насны, 250 орчим морь уралдаж, хүүхэд хамгааллын чиглэлээр сумын Хамтарсан баг үйл ажиллагаа явуулж, Able программд 146 уяач 82 хүүхдийн мэдээллийг оруулсан. Мөн уралдааны замд гарахаас өмнө хамгаалалтын хувцас хэрэгсэл, гэнэтийн ослын даатгалыг шалгаж ажиллалаа.

Ганданчойнхорлин хийдийн 10 жилийн ойд зориулсан 2 насны морьдын уралдаан 08 дугаар сарын 21-нд зохион байгуулагдаж, 64 морь уралдаж, уралдааны үеэр хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллалаа.

Хамтарсан баг 1 кейс шинээр нээн ажиллаж 3 иргэнийг аймгийн хамгаалах байранд байрлуулаа.

108 утсанд ирсэн дуудлагын дагуу хүүхдийн эсрэг хүчирхийллийн 1 кейс нээж, уг гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийж ажиллаж байна.

Сумын аварга адуучин шалгаруулах тэмцээнийг 8 дугаар сарын 19-нд зохион байгуулж 51 адуучин залуус оролцсон.

2023 оны 08 дугаар сарын байдлаар Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан нийт 15 иргэдийн 142 747 396 төгрөг байна. Үүнээс хугацаа дуусаагүй 9 зээлдэгчийн 76 225 805 төгрөг, хугацаа хэтэрсэн чанаргүй 6 зээлдэгчийн 66 521 591 төгрөгний үлдэгдэл байна. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн мэдээллийг төв сервер рүү илгээж нэгтгэн тайлан илгээсэн.

Долоо хоног бүрийн Даваа гарагт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг программд тогтмол оруулж байна.

Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангаас зээл авах хүсэлт гаргаж байгаа сумын “Батбэх найрамдал хоршоо”-ны төслийг нэгтгэн, хүсэлтийг цахимаар хүргүүллээ.

2023 оны 08 дугаар сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3479, өрх 1003, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн 49 , нас барсан 8 хүн бүртгэгдсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

8 дугаар сарын 8-нд шилэн дансанд байгууллагуудын сарын төсвийн гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл, бусад мэдээ мэдээллийг шивж оруулсан.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтын ажлын хэсэг 8 дугаар сарын 10-нд суманд ажиллаж, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2022 онд хийж гүйцэтгэсэн ажилд гүйцэтгэлийн үнэлгээ хийлээ.

8 дугаар сарын 1-нд хуралдсан ИТХ-ын ээлжит 12 дугаар хурлын 03 тоот тогтоолоор сумын төсөвт тодотгол хийсэн. Төсвийн хуваарийг өөрчилж, баазаа аймагт нэгтгүүлэн, Сангийн яамруу хүргүүлсэн.

Статистикийн сарын мэдээ болох оёдол, блок, модон эдлэл, талх нарийн боов үйлдвэрлэлийн мэдээнүүдийг цуглуулан статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд мал угаалгын ажил хийгдэж байна. 2023 оны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд үхэр 10000, хонь 107600, ямаа 77600 нийт 195200 мал төлөвлөгдсөнөөс үхэр-0, хонь- 14300, ямаа-9200, нийт 23500 мал хамрагдаад байна. Мал угаалгын ажил 12%-тай явагдаж байна.

Мөн хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт сумын бүх хурганд хийгдэх тул тус ажилтай холбогдуулан аймгийн мал эмнэлгийн газраас вакциныг нэг удаа татан авч аж ахуй нэгжүүддээ хуваарилан өгөөд байна.

Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хийгдэх бруцеллёз өвчний вакциныг татан авах ажил хийгдэж байна.

Орон нутгийн вакцинжуулалт болох дотрын халдварт хордлого, дуут, боомын вакциныг аймгийн мал эмнэлгийн газраас татан аваад байна.

Түвшинширээ сумын хүн амын ундны усны эх үүсвэр болох гүний болон зөөврийн усан сан бүхий 5 худагт аймгийн БОАЖГ-аас бэлтгэсэн хог хаягдал, хязгаарлалтын мэдээллийн 10 самбарыг байршууллаа.

“Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хаврын тарилтаар 4800 мод тарьсан ба усалгааг хуваарь гарган 7 хоног бүр услаж, усалгаа арчилгааг хуваарийн дагуу хийж байна.

2023 оны 08 дугаар сарын 11-12-нд шилжих шөнө тус сумын нутаг дэвсгэрт алтны судал илэрч хууль бус алт олборлогчид орж ирсэн ба нутгийн ард иргэдийн мэдээллийн дагуу цагдаагийн байгууллагатай хамтарч шуурхай арга хэмжээ авч ажилласан. 6 авто машинтай 14 хүнийг баривчилж цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Тус газарт 8 дугаар сарын 12-оос эхлэн гэр пост гарган ЗДТГ-ын ажилчид, ард иргэдийн хамт эргүүл хийж ажилласаар байна.

Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажил хуваарийн дагуу сар бүр тогтмол хийгдэж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Цэцэрлэгийн 2020 онд шинэ ашиглалтад орсон барилгын эвдрэл гэмтлээс болж үйл ажиллагаа явуулах боломжгүй гэсэн комиссын дүгнэлт болон аймгийн Засаг даргаар ахлуулсан баг газар дээр ирж ажиллаж цэцэрлэгийн байрыг хуучин байр руу нүүлгэх шийдвэрийг гаргаж аймгийн Засаг даргын тамгын газраас 5 ханатай гэр 4ш, 4 ханатай гэр 5ш-ийг шийдэж

өгснийг барьж тохижуулж, сургалт хичээлийн үйл ажиллагаа явуулахад бэлдэж байна.

Цэцэрлэгийн 2023-2024 онд хичээл сургалтын үйл ажиллагаа явуулах хуучин цэцэрлэгийн байранд урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хүүхдийн цэцэрлэгийн 20 албан хаагчийг аймгийн нэгдсэн эмнэлэгт хамрууллаа.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Сумын түүх соёлын үл хөдлөх дурсгалд бүртгэлтэй хөшөө болох Түвшинширээ сум болон сумын сургуулийг үүсгэн байгуулагч хорондоо ноён Дэлэгийн Цэрэнтогтохын хөшөөг түүний төрөл төрөгсөд шинэчлэн босголоо.

“НҮҮДЭЛЧИН-2023” дэлхийн соёлын фестивальд сумын соёлын биет бус өвийг өвлөн уламчлагч М.Батцэцэг амжилттай оролцсон.

Хүүхдийн урлагийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ИХ ЗАСАГ, СУИС, ШУТИС сургуулийн 3 оюутантай хамтран зуныг зугаатай өнгөрөөх “ХАМТДАА ХӨГЖЬЕ” сэдэвт хэл яриа хөгжүүлэх, илтгэх урлаг, бүжиг, өв соёл, бийрэн бичвэрийн сургалтыг 08 дугаар сард зохион байгууллаа. Ярих ур чадварын сургалтад 10 хүүхэд, бүжгийн сургалтад 26 хүүхэд, бийрэн бичвэрийн сургалт насанд хүрэгч-1, хүүхэд-4, өв соёлын сургалтад -6 хүүхэд, нийт давхардсан тоогоор 46 хүүхэд хамрагдсан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 736, алсын дуудлага 9, гэрийн дуудлага 5, хэвтэн эмчлүүлэгч 28, халдвартай бүсэд хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн байхгүй.

Товлолын вакцинд 16 хүүхэд хамрагдсан.

Тус эрүүл мэндийн төвийн сэргээн засах эмчилгээнд бумба-12, гэрэл эмчилгээ-9, бариа засал-16 иргэн тус тус хамрагдсан.

Тухайн сард лабораторийн хийсэн шинжилгээ үйлчилгээ: сахар – 1, элэгний В, С вирусын шинжилгээ – 3, үе мөч-3, БЗХӨ-10 хүн тус тус хамруулаад байна.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗХМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг